




ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2024 XI



www.1212.mn



Дундговь аймаг
2024 он

ГАРЧИГ

Нийгмийн үзүүлэлт:

I.	Ажлын байрны зуучлал.....	3
II.	Бүртгэлтэй ажил хайгч иргэд.....	4
III.	Нийгмийн даатгал.....	4
IV.	Эрүүл мэнд.....	5
V.	Гэмт хэрэг.....	6
VI.	Гамшиг ослын мэдээ.....	7

Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк.....	8
II.	Төсөв.....	8
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ.....	9
IV.	Аж үйлдвэр.....	10

Хавсралт хүснэгтүүд

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН СТАТИСТИКЧ

Нийгмийн үзүүлэлт:

I.	Ажлын байрны зуучлал	С.Доржханд
II.	Бүртгэлтэй ажил хайгч иргэд	С.Доржханд
III.	Нийгмийн даатгал	С.Өсөхбаяр
IV.	Эрүүл мэнд	С.Өсөхбаяр
V.	Гэмт хэрэг	Г.Ариунжаргал
VI.	Гамшиг ослын мэдээ	С. Өсөхбаяр

Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк	Т.Бямбасүрэн
II.	Төсөв	Т.Бямбасүрэн
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ	Г.Ариунжаргал
IV.	Хөдөө аж ахуй	С.Өсөхбаяр
V.	Аж үйлдвэр	Т.Бямбасүрэн


Шинэ ажлын байранд 937 хүн зуучлагджээ



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 11 сарын мэдээгээр нийт 937 хүн шинэ ажлын байранд зуучлагджээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 315 хүнээр буурсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 479 буюу 51.1 хувь нь эмэгтэйчүүд байна.


Ажилд зуучилсан иргэдийн 53.5 хувь буюу 501 нь төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад, 45.7 хувь буюу 428 нь хувийн хэвшилд, 1 иргэн гадаадын, 7 иргэн гадаад улстай хамтарсан эзэмшлийн байгууллагад зуучлагджээ.

ЗУРАГ 1. АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд Хөдөө аж ахуйн салбарт 288 хүн буюу 30.7 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт 105 хүн буюу 11.2 хувь, усан хангамж, бохир ус, зайлуулах салбарт 101 хүн буюу 10.8 хувь, боловсролын салбарт 89 хүн буюу 9.5 хувь, уул уурхай олборлох үйлдвэрийн салбарт 49 хүн 5.2 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 74 хүн буюу 7.9 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 64 хүн буюу 6.8 хувь, бусад салбарт 167 хүн буюу 17.8 хувь нь зуучлагджээ.

ЗУРАГ 2. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, эдийн засгийн салбараар, хувиар




Бүртгэлтэй ажил хайгч 244 иргэн байна



2024 оны 11 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 244 хүн бүртгэгдсэн нь өмнөх сараас 78 хүнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 54.5 хувь буюу 133 нь эмэгтэйчүүд байна. Тус аймгийн хувьд 10000 хүнд ногдох бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 75 байна. Ажил хайгч иргэдийн 30.3 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 33.2 хувийг суурь боловсролтой иргэд, 13.1 хувийг бага боловсролтой иргэд, 8.2 хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд, 14.8 хувийг дээд боловсролтой иргэд бүрдүүлж байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, /боловсролын түвшнээр/




Нийгмийн даатгалын сангийн орлого 15.2 тэрбумаар өссөн байна



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2024 оны эхний 11 сарын байдлаар 71.4 тэрбум төгрөг, зарлага 70.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 15.2 тэрбум төгрөгөөр буюу 27 хувиар, зарлага 10.6 тэрбум төгрөг буюу 17.7 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ /хувиар/



Оны эхний 11 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 8923 байна. Нийт тэтгэвэр авагчдын 86.7 хувь буюу 7739 хүн өндөр насны, 8.9 хувь буюу 790 хүн тахир дутуугийн, 2.6 хувь буюу 229 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 165 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Оны эхний 11 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1343, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 21, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 151 хүн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо өмнөх оны мөн үеээс 139 (33.8%) тохиолдлоор буурсан байна




Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2024 оны эхний 11 сарын байдлаар 500 эх төрсөн ба нийт 502 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар буюу 139 төрөлтөөр буурсан байна. Төрсөн эхчүүдийн 96.2 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт 11 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Нас баралтын 206 тохиолдол бүртгэгдсэн


бөгөөд өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор өссөн, нийт нас барсан хүний 65.1 хувь нь эрэгтэй, 34.9 хувь нь эмэгтэй хүн байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 49 буюу 23.8 хувийг эзэлж байна.

2024 оны 11 сарын байдлаар стационарит шинээр 10058 эмчлүүлэгч хэвтэж, 10069 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 73656 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна.

ЗУРАГ 5. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО



ЗУРАГ 6. ЭМЧЛЭГДЭЖ ГАРСАН ХҮНИЙ ТОО



2024 оны эхний 11 сарын байдлаар 167600 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 21.1 хувь, амбулаторийн үзлэг 62.3 хувь, идэвхтэй хяналт 10.4 хувь, гэрийн идэвхтэй үзлэг 5.4 хувь, гэрийн дуудлагын үзлэг 0.8 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.8 хувь нь эрэгтэй, 64.2 хувь нь эмэгтэй хүн байна

2024 оны эхний 11 сарын байдлаар 272 халдварт өвчин бүртгэгдэж 10 000 хүн амд 58.3 промилль болж өнгөрсөн оны мөн үеэс 139 тохиолдол буюу 33.8 хувиар буурсан байна.


Хулгайлах гэмт хэргийн тоо 25 болж өмнөх оны мөн үеэс 15(37.5%) хэргээр буурсан байна.



Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2024 оны эхний 11 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1673 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 176(11.7%)-р өссөн байна.

2024 оны эхний 11 сард улсын хэмжээнд 39802 гэмт хэрэг бүртгэгдсэний 285 нь Дундговь аймагт бүртгэгдсэн байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 39(15.8%) хэргээр өссөн байна.

ЗУРАГ 7. 2024 ОНЫ ЭХНИЙ 11 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ / Өмнөх 2 оны мөн үетэй харьцуулснаар/



Бүртгэгдсэн нийт 285 гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах гэмт хэрэг 4(4 дахин) хэргээр, хүчиндэх гэмт хэрэг 2(50%) хэргээр, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 39(35.1%) хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 1 хэргээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 18(69.2%) хэргээр хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 2(2 дахин) хэргээр, бусад гэмт хэрэг 1(4.5) хэргээр өссөн бол залилах гэмт хэрэг 6(16.6%) хэргээр бол хулгайлах гэмт хэрэг 15(37.5%) хэргээр, хэрэг дээрэмдэх гэмт хэрэг 2(66.6%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 1(50%) хэргээр буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 261 хүн хохирч, 171 хүн гэмтэж, 5 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо 10(3.9%) хүнээр, гэмтсэн хүний тоо 41(32.0%) хүнээр өссөн бол нас барсан хүний тоо 6(54.5%) хүнээр буурсан байна.

Гэмт хэрэгт нийт 225 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40(21.6%) хүнээр өссөн байна.

Нийт гэмт хэргийн 118(41.4%) нь согтуугаар, 25(8.8%) нь эмэгтэй хүн оролцсон, 42(14.7%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн, 5(1.7%) нь хүүхэд оролцсон, 5(1.7%) нь бүлэглэн гүйцэтгэсэн, 31(10.9%) нь цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг гэмт хэрэг байна.

ЗУРАГ 8. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР /Нийт гэмт хэрэгт эзлэх хувиар/



Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 11 сарын байдлаар 21617 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 1899(9.6%) зөрчлөөр өссөн үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 21132 иргэнийг 990.4 сая төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй

байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 273 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасах, 109 хүнд баривчлах, 58 хүнд саатуулах шийтгэл тус тус ногдуулсан байна. Нийт 32 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14(30.4%) хүнээр буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын 110 дуудлага бүртгэгдсэн байна



Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2024 оны 11 дүгээр сарын байдлаар аюулт үзэгдэл, ослын 110 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс объектын гал түймрийн дуудлага 39 удаа, хээрийн түймэр 2 удаагийн дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 дуудлагаар өссөн үзүүлэлт байна. Хүйтний эрч чангарч галлагаа ихсэн гал түймрийн дуудлага нэмэгдэх хандлагатай байна.

ЗУРАГ 9. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ИРСЭН ДУУДЛАГА




Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өсжээ




Тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид 153 хүн ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 48.5 хувиар өсч, 256.8 тэрбум төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1.6 тэрбум төгрөг, чанаргүй зээл 2.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 10.8 хувиар, чанаргүй зээл 23.6 хувиар өссөн байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 1.4 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.4 хувиар өсч, 117.0 тэрбум төгрөг болжээ.

ЗУРАГ 10. БАНКНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөгөөр



ЗУРАГ 11. БАНКНЫ ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО, мянган хүн, дансны тоогоор




Улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 119.7 хувьтай байна



Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсийн мэдээгээр 2024 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 104.4 хувьтай буюу 26.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Мөн улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 119.7 хувьтай буюу 4.1 тэрбум төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 68.9 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 105.1 хувьтай байна.

ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар



2024 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын нийт дүн 67.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.8 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 60.5 хувиар өсч, 11.4 тэрбум төгрөг болсон нь нийт зардлын 17.0 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оны мөн үеэс 57.4 хувиар өсч, 1.4 тэрбум төгрөг болсон байна.

Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүх зардал өссөн ба үүнээс бараа үйлчилгээний бусад зардал 69.0 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2.2 дахин тус тус өссөн байна.


Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ үнийн индекс өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өссөн байна.



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2024 оны 11 сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувиар өсжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувиар, хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис дүнгээрээ 2.8 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 17.6 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 3.9 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг дүнгээрээ 3.1 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 13. ДҮНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС /Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/



2024 оны 11 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮСНЭГТ 1. ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	XI/04	XI/11	XI/18	XI/25
1	Гурил, 1-р зэрэг, кг	2 867	2 867	2 867	2 867
2	Хонины мах, кг	9 500	9 000	9 500	9 500
3	Үхрийн мах, кг	15 000	15 000	15 000	15 000
4	Ямааны ястай мах, кг	8 500	8 000	8 000	8 000
5	Элсэн чихэр, кг	4 697	4 697	4 697	4 697
6	Цагаан будаа, кг	3 963	3 963	3 963	3 963
7	Шингэн сүү, л	6 000	6 000	6 000	6 000
8	Ноолуурын үнэ 1 кг	120 000	120 000	120 000	120 000
9	Бензин А-80, 1литр	0	0	0	0
10	Бензин А-92, 1литр	2 530	2 530	2 530	2 530
11	Дизель түлш 1 литр	3 500	3 500	3 250	3 250
12	Боодолтой өвс 1 ш	13 000	15 000	14 000	15 000

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 38.3 хувиар өслөө



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2024 оны эхний 11 сарын байдлаар 66.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 38.3 хувиар өсжээ. Энэхүү өсөлтөд уул уурхай олборлох салбар 42.0 хувь өссөн нь голлон нөлөөлсөн байна.


ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, салбараар, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, сая төгрөгөөр

Салбар	Үйлдвэрлэл		Борлуулалт		Өөрчлөлт %	
	2023	2024*	2023	2024*	Үйлд	Бор
Нийт дүн	47969.0	66353.0	80491.9	79042.8	138.3	98.2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	39945.3	56734.8	71214.2	68057	142.0	95.6
Боловсруулах аж үйлдвэрлэл	1865.7	2069.4	2088.7	2318.6	110.9	111.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3988.9	5169.4	5019.9	6287.9	129.6	125.3
Ус хангамж; сувагжилтын систем	2169.1	2379.4	2169.1	2379.3	109.7	109.7

*-Урьдчилсан гүйцэтгэлээр

Мөн тус салбарын борлуулалт 2024 оны эхний 11 сарын байдлаар урьдчилсан гүйцэтгэлээр 79.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар буюу 1.4 тэрбум төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 14. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, /нийт үйлдвэрлэлд эзлэх хувиар/



ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

I. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2024 оны 11 сарын байдлаар

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
Бүгд	937	479	100.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	288	136	30.7
Уул уурхай олборлох үйлдвэр	49	10	5.2
Боловсруулах аж үйлдвэр	74	38	7.9
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	0	0	0.0
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	101	28	10.8
Барилга	16	1	1.7
Бөөний ба жижиглэн худалдаа	25	19	2.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2	1	0.2
Зочид буудал, зоогийн газар	13	12	1.4
Мэдээлэл холбоо	10	5	1.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13	11	1.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	7	5	0.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	64	34	6.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	105	51	40.0
Боловсрол	89	76	9.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	27	21	2.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0	0	0.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	52	29	5.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2	2	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0	0.0

II. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажил хайгч иргэд	Тайлант сарын эцэст байгаа ажил хайгч иргэд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажил хайгч
Дүн	32 721	166	244	133	75
Сайнцагаан	11 073	54	55	33	50
Адаацаг	1 910	3	6	5	31
Баянжаргалан	879	1	5	2	57
Говь-Угтаал	1 060	1	7	2	66
Гурвансайхан	1 548	0	1	1	6
Дэлгэрхангай	1 550	2	1	0	6
Дэлгэрцогт	1 136	4	8	2	70
Дэрэн	1 494	16	37	21	248
Луус	1 385	15	35	18	253
Өлзийт	1 704	1	1	1	6
Өндөршил	1 038	2	4	2	39
Сайхан-Овоо	1 524	57	56	33	367
Хулд	1 704	7	10	5	59
Цагаандэлгэр	701	0	8	3	114
Эрдэнэдалай	4 015	3	10	5	25

III.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА/сая.төг/

	2023 оны XI сар	2024 оны XI сар			2024 XI 2023 XI хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	56 240.5	34 974.2	71 432.1	204.2	127.0
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	49 189.8	31 737.4	67 824.1	213.7	137.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	2 149.4	1 743.1	2 735.9	157.0	127.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3 305.8	.0	.0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	1 021.3	947.8	147.3	15.5	14.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	574.2	545.9	724.8	132.8	126.2
Нийгмийн даатгалын сангийн зарлага	60 000.8	72 373.3	70 589.7	97.5	117.6
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	52 982.3	68 332.2	67 074.3	98.2	126.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	2 171.2	3 116.7	2 618.9	84.0	120.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3 304.6	.0	.0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	959.1	208.0	157.4	75.7	16.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	583.6	716.4	739.1	103.2	126.6

Тайлбар: *Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

IV.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, жил бүрийн 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 XI	2021 XI	2022 XI	2023 XI	2024 XI	2024 XI 2023 XI
	хүн					хувь
Тэтгэвэр авагчдын тоо	7 697	7 921	8 182	8 394	8 923	106.3
Өндөр настны тэтгэвэр	6 430	6 708	6 978	7 206	7 739	107.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр	886	825	813	799	790	98.9
Цэргийн тэтгэвэр	143	145	160	164	165	100.6
Бусад тэтгэвэр	238	243	231	225	229	101.8

V. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Дүн	642	502	204	206	7	1	10	2
Сайнцагаан	608	483	94	95	7	1	8	1
Адаацаг	1	1	7	9	0	0	0	0
Баянжаргалан	2	0	12	8	0	0	0	0
Говь-Угтаал	4	0	4	5	0	0	0	0
Гурвансайхан	0	0	6	8	0	0	0	1
Дэлгэрхангай	8	3	8	13	0	0	0	0
Дэлгэрцогт	0	0	9	4	0	0	0	0
Дэрэн	1	2	9	9	0	0	1	0
Луус	0	1	8	8	0	0	0	0
Өлзийт	3	1	6	4	0	0	0	0
Өндөршил	2	2	11	5	0	0	0	0
Сайхан-Овоо	2	0	4	5	0	0	0	0
Хулд	2	0	3	2	0	0	0	0
Цагаандэлгэр	2	0	2	1	0	0	0	0
Эрдэнэдалай	7	9	21	30	0	0	1	0

VI. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 11 сарын байдлаар

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		Салхин цэцэг	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Дүн	9 380	10 058	165 640	167 600	49 173	45 085	411	272	9	21	145	134
Сц	5 033	5 486	128 325	125 147	41 882	37 815	260	190	5	12	96	90
Ад	201	279	2 730	3 440	599	181	41	4	2	3	9	
Бж	155	140	1 560	2 282	177	282	2	5			2	4
Гу	181	330	2 483	2 869	907	659	9	2			2	2
Гс	117	190	2 420	2 386	322	268	9	13		2	4	7
Дх	258	270	1 929	1 334	83	63	5	3	1			1
Дц	173	241	1 255	831	200	263	7	5	1			1
Дн	165	144	1 875	3 693	247	394	7	9			1	7
Лс	192	218	2 434	3 181	140	142	5	8			1	3
Өт	134	133	2 237	1 624	145	88	37	3		1	27	
Өш	254	183	1 972	1 815	457	199	3	5				4
Со	109	108	708	922	262	337	7	1		1	2	
Хд	111	150	890	1 618	208	96	7	5		1		1
Цд	158	208	944	835	379	353	3	13				13
Эд	490	596	10 623	11 582	2 683	3 406	9	6		1	1	1
Мд	167		171									
Эб	321	191	319	196								
МУЭ төв	1 161	1 191	2 765	3 845	482	539						

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

VII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

Үзүүлэлт	2023 I-XI	2024 I-XI	23/24 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30578	29933	97.9
Бүх хэрэг	246	285	115.9
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	1	4	-
Хүчиндэх гэмт хэрэг	4	6	150.0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	1	2	200.0
Дээрэмдэх гэмт хэрэг	3	1	33.3
Хүрээлэн байгаа орчны эсрэг	0	1	-
Танхайн хэрэг	0	0	-
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	111	150	135.1
Бусдын эд хөрөнгийн хулгай	40	25	62.5
Малын хулгай	2	1	50.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	26	44	169.2
Залилангийн хэрэг	36	30	83.3
Эдийн засгийн гэмт хэрэг	0	0	-
Бусад	22	21	95.5
Эмэгтэй хүн оролцсон	26	25	12.0
Согтуугаар	74	118	159.5
Бүлэглэж	6	5	83.3
Хүүхэд оролцсон	6	5	83.3
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	8	42	525.0
Цахим орчид үйлдэгдсэн гэмт хэрэг	26	31	119.2
Хөнгөн	218	234	107.3
Хүнд	28	51	182.1
Гэмт хэрэгт холбогдогсод	185	225	121.6
Учирсан бүх хохирол /сая.төг/	1042.4	865.5	83.0
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	566.4	525.8	92.8
Илрүүлэлтийн хувь	63.0	65.5	104.0
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	80	95	118.4

VIII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

№	Үзүүлэлтүүд	2023 I-XI	2024 I-XI	2023/2024 хувь
1	Гэмт хэргийн улмаас:	141	176	124.8
	Нас барсан	11	5	45.5
	Гэмтсэн	130	171	131.5
2	Зам тээврийн осолын улмаас:	25	13	52.0
	Нас барсан	8	2	25.0
	Гэмтсэн	17	11	64.7
3	Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо /Үүнээс/	251	261	104.0
	Эмэгтэй	89	107	120.2
	7 хүртэлх насны	5	1	20.0
	8-13 насны	4	4	100.0
	14-17 насны	14	7	50.0
4	Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл	1497	1673	111.8
	Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ	582	717	123.2
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	202	277	137.1
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	347	399	115.0
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	8	12	150.0
	Үлдэгдэл	25	29	116.0
	Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн	76	71	93.4
	6-ба түүнээс дээш	481	617	128.3
5	Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл /Үүнд/	915	956	104.5
	5 хоногт	814	944	116.0
	6 ба түүнээс дээш	93	3	3.2
	Үлдэгдэл	8	9	112.5
6	Нийт зөрчил	19718	21617	109.6
7	Илрүүлсэн зөрчил			
	ЗЦТасгаас илрүүлсэн	13411	12998	96.9
	НХЖХТасгаас илрүүлсэн	6307	8619	136.7
8	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон	287	273	95.1
9	Баривчлагдсан хүн	198	109	55.1
10	Журамласан тээврийн хэрэгсэл	405	287	70.9
11	Эрүүлжүүлэгдсэн хүн	46	32	69.6
12	Саатуулагдсан хүн	74	58	78.4
13	Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан			
	Хүний тоо	19209	21132	110.0
	Мөнгөн дүн /мян.төг/	885289.9	990358.5	111.9

IX. ГАМШГИЙН МЭДЭЭ

Үйл ажиллагаа	2023 оны I-XI сар	2024 оны I-XI сар	2023/2024 хувь
Нийт ирсэн дуудлага	94	110	117.0
хээрийн түймэр	0	2	0.0
Объектын гал түймрийн	25	39	156.0
Хүчтэй салхи шуурга	30	1	3.3
Усны осол	0	1	0.0
Төөрсөн сураггүй болсон	7	9	128.6
Зам тээврийн осол	4	3	75.0
Уурхайн осол	1	0	0.0
Аянга	0	0	0.0
Малын гоц халдварт	22	31	140.9
Цас, шаварт суусан	2	22	1100.0
Газар хөдлөлт	3	2	66.7
Дуудлагын үр дүн			
Аварсан хүн	38	119	313.2
Аварсан хөрөнгө /сая.төг/	1,282	2,669	208.2
Хохирол /сая.төг/	458.2	431.2	94.1
Иргэд ААН-д хандсан үйл ажиллагаа			
ААН-ийн хүсэлт	84	102	121.4
Иргэдийн өргөдөл	61	39	63.9
Хяналт шалгалт			
Хамрагдсан объект	178	181	101.7
Илэрсэн зөрчил	498	328	65.9
Газар дээр нь арилгасан	153	191	124.8
Албан шаардлага	74	84	113.5
Мэдэгдэл	76	83	109.2
Торгууль /сая.төг/	0.5	5.2	1040.0

Х. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр, тоогоор

			(Сая.төгрөг, тоогоор)		
Үзүүлэлт			Үлдэгдэл		2024/2023 хувь
			2023 I-XI	2024 I-XI	
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл		172 847.4	256 755.9	148.5
	Үүнээс:	Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	1 416.2	1 568.5	110.8
		Чанаргүй зээлийн үлдэгдэл	1 643.3	2 031.9	123.6
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл		26 866.4	39 078.3	145.5
	Үүнээс:	Иргэдийн харилцахын үлдэгдэл	21 176.1	26 451.1	124.9
		Нийт хадгаламжийн үлдэгдэл	89 074.9	117 037.0	131.4
	Үүнээс:	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	89 033.8	111 975.8	125.8
		Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	12 953.6	19 741.7	152.4
		Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	76 121.4	97 295.3	127.8
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо		34	34	100.0
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо		167	153	91.6
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)		27 492	28 538	103.8
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		89 439	92 592	103.5
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		31 578	35 057	113.7
	Нийт АТМ-ны тоо		19	20	105.3
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо		42 856	42 214	98.5

XI. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2024 I-XI			2024 XI		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дүн	29011989.5	41141390.5	141.8	1848140.5	7690391.6	416.1
Сайнцагаан	7352848.9	8255961.1	112.3	739108.3	767232.2	103.8
Адаацаг	451330.0	484531.2	107.4	46130.0	47662.1	103.3
Баянжаргалан	8396502.4	8511115.6	101.4	129161.3	179464.8	138.9
Говь-Угтаал	497947.1	638178.1	128.2	47070.0	40911.5	86.9
Гурвансайхан	5007911.5	8035277.6	160.5	167765.0	150979.4	90.0
Дэлгэрхангай	677360.0	942910.2	139.2	80890.0	152209.4	188.2
Дэлгэрцогт	321930.0	354124.1	110.0	26300.0	36817.5	140.0
Дэрэн	439140.0	564440.2	128.5	25960.0	32922.7	126.8
Луус	359060.0	381636.5	106.3	39540.0	45174.2	114.2
Өлзийт	1570104.9	1517771.6	96.7	144753.8	49591.2	34.3
Өндөршил	489440.0	560879.9	114.6	54160.0	22253.3	41.1
Сайхан-Овоо	467398.0	490527.3	104.9	36664.0	60129.2	164.0
Хулд	392192.0	531532.2	135.5	24846.0	49878.9	200.8
Цагаандэлгэр	221570.0	264666.6	119.5	22400.0	18556.9	82.8
Эрдэнэдалай	1251255.0	1175893.5	94.0	150090.0	103302.2	68.8
Дундговь	1115999.7	8431944.8	755.6	113302.1	5933306.1	5236.7

XII. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

Зарлагын төрөл	2023 I-XI	2024 I-XI			24/23 хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зарлага	44 681.2	97 366.9	67 150.1	69.0	150.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7 099.1	12 297.8	11 392.6	92.6	160.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	873.0	1 554.2	1 373.9	92.6	157.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 080.6	7 979.7	7 196.5	88.4	141.6
Хангамж бараа материалын зардал	523.0	852.4	608.6	71.4	116.4
Норматив зардал	100.3	123.4	108.8	88.2	108.5
Эд хогшил урсгал засварын зардал	659.5	1 226.6	875.7	71.4	132.8
Томилолтын зардал	226.9	353.8	304.4	86.0	134.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	996.9	3 557.7	2 145.5	60.3	215.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3 511.3	8 206.9	5 934.8	72.3	169.0
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	.0	419.3	.0	-	-
Татаас	1 308.9	1 949.0	1 947.8	99.9	148.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	8 945.2	13 413.1	13 321.1	99.3	148.9
Бусад урсгал шилжүүлэг	189.3	1 686.2	1 395.8	82.8	737.3
Хөрөнгийн зардал	13 832.3	41 470.9	20 454.2	49.3	147.9
Эргэж төлөгдөх зээл	1 334.9	2 275.9	90.4	4.0	6.8

ХИИ.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	мөр	2023 I-XI	2024 I-XI			24/23 хувь
			төл	гүйц	хувь	
Нийт тэнцвэржүүлсэн орлого /тусламжийн дүн/	1	35 792.3	65 588.5	68 944.5	105.1	192.6
A.Урсгал орлого	2	11 360.3	34 580.0	37 980.8	109.8	334.3
I.Татварын орлого	3	9 696.3	25 748.2	26 874.9	104.4	277.2
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	5 881.2	20 950.8	22 368.5	106.8	380.3
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	5 763.7	8 521.1	9 472.6	111.2	164.3
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	- 406.7	- 601.9	- 601.8	100.0	148.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	7	235.0	10 775.8	10 600.0	98.4	4510.6
1.2 үйл ажиллагааны орлого	8	138.9	1 423.8	1 883.6	132.3	1356.1
1.3 Хөрөнгө борлуулсаны	9	3.6	132.7	253.9	191.3	7052.8
1.5 Бусад татвар	10	146.7	699.3	760.2	108.7	518.2
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	11	152.5	188.0	263.7	140.3	172.9
3. Авто тээврийн хэрэгслийн	12	333.3	320.0	362.4	113.3	108.7
4. Бусад татвар	13	3 329.3	4 289.4	3 880.3	90.5	116.6
4.1 Улсын тэмдэгтийн	14	136.0	143.6	261.9	182.4	192.6
4.2 Ашигт малтмал нөөцийн	15	13.8	118.2	10.3	8.7	74.6
4.3 Газрын төлбөр	16	1 454.6	1 835.2	1 611.4	87.8	110.8
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	17	125.6	171.2	169.7	99.1	135.1
4.6 Усны төлбөр	18	597.2	499.6	691.2	138.4	115.7
4.7.Малд ногдуулах татвар	19	792.1	1 064.6	613.5	57.6	77.5
4.8.Бусад	20	210.0	457.0	522.3	-	248.7
II.Татварын бус орлого	21	1 664.0	8 831.8	11 105.9	125.7	101.6
2.1 Бусад нэр заагдаагүй	22	1 664.0	8 831.8	11 105.9	125.7	667.4
Б. Хөрөнгийн орлого	23	237.8	90.0	138.8	154.2	58.4
В.Тусламжийн орлого	24	24 194.2	30 918.5	30 824.9	99.7	127.4
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	15 315.6	18 195.6	18 195.6	100.0	118.8
Аймаг нийслэлээс авсан татаас	30	7 065.9	9 176.5	9 176.5	100.0	129.9
Сум дүүргээс авсан тэгшитгэл	31	1 812.7	3 546.4	3 452.8	97.4	190.5
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	32	11 598.1	34 670.0	38 119.6	109.9	328.7
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	33	2 496.9	3 443.0	4 120.8	119.7	165.0
Аймгийн нийт орлого	34	14 095.0	38 113.0	42 240.4	110.8	299.7

XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 11-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ /аймгаар/

Нэр төрөл		Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	3 550	3 125	3 483	3 233
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	2 867	2 550	2 927	2 667
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	1 767	1 700	1 587	1 950
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	2 330	2 600	2 597	2 467
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	2 413	2 567	2 583	3 033
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	6 333	5 583	5 217	4 533
7	Жигнэмэг /наша марка/150-180г, цайны/	2 917	1 850	1 880	1 833
8	Цагаан будаа, задгай, кг	3 963	3 850	4 250	3 633
9	Шар будаа, задгай, кг	3 233	2 300	3 125	2 733
10	Хонины мах, кг	9 167	9 000	10 000	10 500
11	Адууны мах, кг	9 667	8 500	10 000	10 000
12	Ямааны мах, кг	8 167	8 000	9 000	9 000
13	Дотор мах, цувдай, цусгүй	4 333	17 500	5 000	5 000
14	Хиам чанасан, 1кг	15 800	-	-	16 267
15	Сүү, задгай, л	5 667	4 750	6 000	4 250
16	Сүү савласан, 1л. Шимт сүү	5 480	5 350	5 597	5 433
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	37 667	40 000	35 000	32 500
18	Өндөг,ш,дотоод	673	573	633	600
19	Ургамлын тос, 1литр, Олайна	11 167	10 800	10 993	7 467
20	Өөхөн тос, кг	-	-	-	4 000
21	Шар тос, кг	29 000	60 000	35 000	42 500
22	Цөцгийн тос, задгай, кг	9 250	7 567	6 595	5 975
23	Төмс дотоод, кг	1 563	1 100	3 300	1 700
24	Лууван хятад, кг	2 430	1 767	-	3 000
25	Байцаа хятад, кг	1 945	1 583	2 797	2 500
26	Сонгино хятад, кг	3 163	2 133	3 150	3 000
27	Элсэн чихэр, кг, орос	4 697	4 200	4 490	4 250
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	12 633	12 100	12 167	12 133
29	Шоколад, "Alpen gold"	3 597	3 850	4 037	3 600
30	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	2 563	3 517	3 993	3 000
31	Майноз, /Улаанбаатар 500г/	7 063	5 500	6 680	6 850
32	Кетчуп, 900г, Чили Полиш	3 530	4 983	4 150	3 250
33	Ногоон цай, Stimo, савласан 90г	4 050	4 217	2 680	3 433
34	Байхуу цай, Lipton, 20 ширхэгтэй	4 997	5 000	5 513	4 767
35	Цагаан архи, 0.75 ARKHI EXPORT	29 233	29 933	30 913	30 100
36	Пиво, "Cass", 0.5л	4 400	4 217	4 313	4 250
37	Янжуур тамхи, /Esse/, саарал	4 083	3 900	3 633	3 450
38	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	3 100	2 783	2 433	2 210
39	Бензин, А-80, 1 литр	-	2 460	-	-
40	Бензин, А-92, 1 литр	2 530	2 480	2 548	2 520
41	Дизель түлш, 1 литр	3 500	3 183	3 280	3 270

ХVI. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

	2024 XI 2023 XI	2024 XI 2023 XII
ЕРӨНХИЙ ИНДЭКС	105.4	104.9
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	106.4	104.7
01.1 ХҮНСНИЙ БАРАА	105.7	103.9
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	104.2	103.3
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	114.5	110.6
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	122.6	121.0
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	106.5	101.2
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	111.5	110.3
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	103.7	103.5
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	92.4	91.5
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	106.4	106.4
01.1.9 БЭЛЭН ХООЛ, ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	110.9	110.0
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	112.4	112.4
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	102.8	102.7
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	104.6	104.4
02.2 ТАМХИ	101.9	101.9
03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ	104.7	104.5
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	103.5	103.4
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	101.4	101.4
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	103.9	103.8
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	101.2	101.2
03.2 ГУТАЛ	106.7	106.1
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	117.6	117.2
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	105.9	105.9
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	103.5	103.5
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	136.0	136.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	127.8	127.0
Барааны бүлгээр	2024 XI 2023 XI	2024 XI 2023 XII
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	103.9	103.9
05.1 ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	106.9	106.9
05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	108.5	107.9
05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	99.7	99.7
05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	108.7	108.7
05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	105.4	105.2
05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.6	100.6
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.1	102.5
06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	103.4	102.6
06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	101.0	101.0
06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	104.3	104.3
07. ТЭЭВЭР	99.0	98.7
07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	100.0	100.0
07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	96.8	96.4
07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	107.5	107.5
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.3	101.3
08.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ	101.2	101.2
08.3 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	101.4	101.4
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	103.3	103.3
09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	100.0	100.0
09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	106.6	106.6
09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	103.8	103.8
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	111.0	111.0
11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	110.7	110.7
11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	148.4	148.4
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	110.5	110.3
12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	111.7	111.5
12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	102.5	102.5
12.5 ДААТГАЛ	113.3	113.3
12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

ХVII. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ , оны үнээр, сая төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2023 I-XI	2024 I-XI	2024/2023
Нийт дүн	47 969.0	66 353.0	138.3%
Уул уурхай олборлолт	39 945.3	56 734.8	142.0%
Чулуун нүүрс олборлолт	25 845.6	16 300.9	63.1%
Хүрэн нүүрс олборлолт	117.2	10.4	8.9%
Чулуу, элс шороо олборлолт	3 556.9	252.4	7.1%
Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт	10 425.6	40 171.1	385.3%
Боловсруулах үйлдвэрлэл	1 865.7	2 069.4	110.9%
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 410.0	1 671.5	118.5%
Малын тэжээлийн үйлдвэрлэл	121.5	8.6	7.1%
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	66.2	25.1	37.9%
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	9.2	15.4	167.4%
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	193.0	243.1	126.0%
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	14.3	15.6	109.1%
Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл	51.5	90.1	175.0%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3 988.9	5 169.4	129.6%
Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа	3 988.9	5 169.4	129.6%
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	2 169.1	2 379.4	109.7%
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	1 767.6	2 001.9	113.3%
Хог хаягдлыг цуглуулах	401.5	377.5	94.0%

ХVIII. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 I-XI	2024 I-XI	2024/2023 хувь
Нүүрс	мян.тн	452.9	151.6	33.5
Жонш	мян.тн	53.7	65.4	121.8
Дулааны эрчим хүч	мян.гкал	128.3	165.7	129.2
Хүснэгт, маягт	х.д.х	254.8	279.5	109.7
Талх	тн	123.8	124.8	100.8
Нарийн боов	тн	146.4	165.7	113.2
Бялуу	тн	2.5	2.0	80.0
Чихэр	тн	2.2	1.0	45.5
Архи	мян.л	8.1	7.2	88.9
Хэрчсэн гурил	тн	14.5	9.3	64.1
Хоормог	мян.л	0.3	0.1	33.3
Ааруул	тн	0.4	0.3	75.0
Түгээсэн цэвэр ус	мян.т ³	236.1	239.2	101.3
Сувагжуулалт	мян.м ³	157.7	168.1	106.6

Мэдээлэл авах холбооснууд:

<http://www.dundgovi.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 01 сарын 15

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн

дарга

Б.Энхтуяа

Утас: (976)-70593777

Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн

Мэргэжилтэн

С.Доржханд

Мэргэжилтэн

Г.Ариунжаргал

Утас: (976)-70593715



Dundgovi@nso.mn



70593715



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

110

Авлигыг мэдээлэх утас